

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Үндсэн Хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.”, 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж тус тус заасан.

Татварын ерөнхий хуульд татварын тэгш, шударга байх, тодорхой ойлгомжтой байх, давхар татвар ногдуулахгүй байх зарчмуудыг тус тус хуульчилсан байдаг.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь заалт нь татвар төлөгчийг ялгавартай байдалд оруулах, үндсэн хөрөнгөд хөрөнгө оруулалт хийсэн этгээдэд татварын ачаалал үүсгэх, өмчийн үр өгөөжийг ашиглах боломжийг хугацаагаар хязгаарлах зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож байна.

1.2.Практик шаардлага:

Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) бол хэрэглээний татвар бөгөөд бизнесийн үйл ажиллагаанд дарамт учруулахгүй байх зарчимд тулгуурладаг. Өнөөдөр хэрэгжиж байгаа Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь заалтаар барилга, байгууламжийн НӨАТ-ыг 10 жил, тоног төхөөрөмжийн НӨАТ-ыг 5 жил, бусад үндсэн хөрөнгийг шууд хасахаар зохицуулсан байна. Энэхүү зохицуулалт нь дараах хүндрэлүүдийг үүсгэж байна:

- Татварын ачаалал бодитоор нэмэгдэж байна. НӨАТ нь хэрэглээний татвар байх ёстой боловч уг зохицуулалтын улмаас бизнесийн зардал болж хувирч, татварын үйл ажиллагаанд баримтлах зарчмууд алдагдаж байна.
- Аж ахуйн нэгжийн санхүүгийн дарамт нэмэгдэж байна. Их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгжүүд НӨАТ-аа шууд хасаж чадахгүйгээс татварын өр үүсэх, эргэлтийн хөрөнгийн хомсдолд орох нөхцөл бий болж байна.

- Хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлж байна. Үндсэн хөрөнгөд хөрөнгө оруулалт хийсэн бизнесүүд импорт, худалдаанд суурилсан үйл ажиллагаатай харьцуулахад татварын дарамтад илүү орж, өрсөлдөх чадвар буурч байна.

НӨАТ-ын тогтолцооны нийтлэг зарчимд хасагдах татварыг хугацаагаар хуваан хасах зохицуулалт байдаггүй. Тухайлбал, Сингапур, Австрали, Казахстан зэрэг улсад үндсэн хөрөнгийн НӨАТ-ыг шууд хасах боломжийг бүрдүүлсэн байдаг.

Монгол Улсын одоогийн зохицуулалт нь олон улсын нийтлэг жишгээс зөрүүтэй байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Энэ хуулийн төслийн зорилго нь үндсэн хөрөнгө бэлтгэхтэй холбоотойгоор төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг хасах хугацааг олон улсын жишигт нийцүүлэн өөрчилж, татварын ачааллыг бууруулах, хөрөнгө оруулалтыг дэмжихэд оршино.

Хуулийн төсөл гурван зүйлтэй. Нэгдүгээр зүйлд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь заалтыг хүчингүй болгох зохицуулалтыг, хоёрдугаар зүйлд шилжилтийн зохицуулалтыг, гуравдугаар зүйлд хуулийн дагаж мөрдөх хугацааг тус тус тусгасан.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгмийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаар:

Хуулийн төслийг баталж хэрэгжүүлснээр дараах эерэг үр дүн гарна гэж үзэж байна. Үүнд:

- Аж ахуйн нэгжийн санхүүгийн чадавх сайжирна. Үндсэн хөрөнгө бэлтгэхтэй холбоотойгоор төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг шууд хасах боломж бүрдсэнээр аж ахуйн нэгжийн эргэлтийн хөрөнгө чөлөөлөгдөж, санхүүгийн дарамт буурна.
- Хөрөнгө оруулалтын идэвх нэмэгдэнэ. Үндсэн хөрөнгөд чиглэсэн татварын ачаалал буурснаар дотоод, гадаадын хөрөнгө оруулалтын орчин сайжирч, үйлдвэрлэл, дэд бүтэц зэрэг салбарт хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.
- Дотоодын үйлдвэрлэл, нэмүү өртөг бий болголт дэмжигдэнэ. Хөрөнгө оруулалтад татварын саад багассанаар аж үйлдвэрийн салбарын өрсөлдөх чадвар нэмэгдэж, дотоодын үйлдвэрлэл, нэмүү өртөг бий болгох үйл ажиллагаа идэвхэжнэ.
- Татварын тогтолцооны үр ашиг, ил тод байдал сайжирна. Нэмэгдсэн өртгийн албан татварын суурь зарчимд нийцүүлэн орцын татварыг шууд

хасах боломж бүрдсэнээр татварын тогтолцоо илүү ойлгомжтой, үр ашигтай болно.

- Аж ахуйн нэгжийн санхүүжилтийн зардал буурна. Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хугацаагаар хойшлогдохгүй болсноор аж ахуйн нэгжүүдийн зээлийн хэрэгцээ буурч, санхүүжилтийн зардал багасна.
- Эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлнэ. Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн идэвхжил нэмэгдсэнээр ажлын байр бий болох, татварын суурь тэлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих нөхцөл бүрдэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэх, холбогдох хууль тогтоомжтой уялдсан байдал, хуулийн төслийг дагалдан гарах хууль тогтоомжийн төслийн талаар:

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн ба бусад хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлага үүсэхгүй.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ